



БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН ЗАСГИЙН
ГАЗАР БА БҮГД НАЙРАМДАХ АРДЧИЛСАН ГЕРМАН
УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХОРООНД 1971 ОНД
ХАРИЛЦАН БАРАА НИЙЛҮҮЛЭХ БА ТӨЛБӨРИЙН ТУХАЙ

ПРОТОКОЛ

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн Газар ба Бүгд Найрамдах Ардчилсан Герман Улсын Засгийн Газрын хооронд 1971-1975 онд харилцан бараа нийлүүлэх ба төлбөрийн тухай 1971 оны I-р сарын **15** нь өдөр Улаанбаатар хотноо байгуулсан хэлэлцээ - рийн үндсэн дээр хоёр улсын засгийн газар дор дурдсанаар тохи-ролцов. Үүнд:

Нэгдүгээр зүйл

Бүгд Найрамдах Монгол Ард Улс ба Бүгд Найрамдах Ардчилсан Герман Улсын хооронд бараа нийлүүлэх явдлыг 1971 оны I-р сарын I-нээс 1971 оны I2-р сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд энэхүү Протоколд хавсаргасан барааны жагсаалтн A/I971/ Бүгд Найрамдах Монгол Ард Улсаас Бүгд Найрамдах Ардчилсан Герман Улсад нийлүүлэх бараа ба Б/I971/ Бүгд Найрамдах Ардчилсан Герман Улсаас Бүгд Найрамдах Монгол Ард Улсад нийлүүлэх барааны жагсаалтуудын үндсэн дээр тогтоосон нэр төрлийн дагуу гүйцэтгэнэ.

Барааны A/I971 ба Б/I971 жагсаалтууд энэхүү Протоколын салмгүй хэсэг болно.

Энэ жагсаалтаар тогтоосон барааны нэр төрөл, тоо хэмжээ заавал гүйцэтгэгдэвэл зохино.

Эдгээр нь зөвхөн хоёр талын зөвшөөрөлцсөнөөр нэмэгдэх буцуу өөрчлөгддөж болно.

Хоёрдугаар зүйл

Энэхүү Протоколын хүрээнд, бараа нийлүүлэх тухайн контрактыг энэхүү Протоколд гарын үсэг зурснаас хойш 3 сарын до-тор тус хоёр орны гадаад худалдааны ажиллагааг явуулах эрх олгогдсон байгууллагуудаас байгуулах болно.

Гуравдугаар зүйл

Бараа нийлүүлэх тухай контракт байгуулах ба төлбөрийг гүйцэтгэхдээ ЭЗХТЗ-ийн гишүүн орнуудын хооронд Бараа Нийлүүлэх Ерөнхий Нөхцлийн /ЭЗХТЗ-ийн I968 оны БНЭН/ дагуу гүйцэтгэнэ.

ЭЗХТЗ-ийн гадаад худалдааны Байнгын Комиссын 22-р хуралдааны зөвлөмжийн дагуу хоёр талын гадаад худалдааны ажиллагаа явуулах эрх олгогдсон байгууллагууд нь Бараа нийлүүлсэн өдрөөс эхлэн тооцох баталгааны хугацааг тогтоохдоо ЭЗХТЗ-ийн I968 оны БНЭН-ийн 29-р зүйлд дурдсан баталгааны хугацааг 2 сараар нэмэгдүүлэхээр контрактад тохиролцено. Мал аж ахуйн гаралтай, турган гэмтдэг барааны талаар гаргах гомдолын хугацааг ЭЗХТЗ-ийн I968 оны БНЭН-ийн 72-р зүйлд дурдсан хугацаанаас нийлээд богино байхаар контракт байгуулахдаа тогтооно.

Дөрөвдүгээр зүйл

Энэхүү Протоколын дагуу нийлүүлийг байгаа барааны үүийг тогтоохдоо ЭЗХТЗ-ийн гишүүн орнуудын хоорондын худалдаанд контрактын үзэ тогтоох талаар Эдийн Засгийн Харилцан Туслалцах Зөвлөлийн байгууллагуудын мөрдөх байгаа зарчим, шийдвэр, зөвлөмжийн үндсэн дээр тогтооно.

Хэлэлцэн тохиролцогч хоёр этгээдийн аль нэгний хүссэнээр эдийн засгийн үндэслэлтэй нөхцөлд контрактын үнийн зохицуулалтын талаар хоёр талын консультац хийж болно.

Тавдугаар зүйл

Энэхүү Протоколын хурээнд Бараа нийлүүлснээс ба үйлчилгээнээс гарах төлбөрүүдийг олон талт тооцооны ба Эдийн Засгийн Хамтын Ажиллагааны Олон Улсын Банк байгуулах тухай I963 оны I0-р сарын 22-ны өдрийн Хэлэлцээрийн заалтын дагуу шилжих рублиэр гүйцэтгэнэ.



3.

Зургадугаар зүйл

Энэхүү Протокол 1971 оны I-р сарын I-нээс эхлэн 1971 оны I2-р сарын 31-нийг дуустал хүчинтэй байна.

1971 оны I-р сарын **15** ны өдөр Улаанбаатар хотноо тус бүр хоёр эх хувийг монгол, герман, орос хэлээр үйлдэж гарын үсэг зурсан бөгөөд монгол ба герман хэл дээрх эх хувиуд нь адил хүчинтэй байна.

Энэхүү Протоколын засалтуудын утгыг тайлбарлахад тодорхой бус зүйл гарвал хоёр тал нь орос хэл дээрхийг үндэслэнэ.

БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД
УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ЭРХ
ОЛГОСНООР

Доржнамж 7

БҮГД НАЙРАМДАХ АРДЧИЛСАН ГЕР-
МАН УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ЭРХ
ОЛГОСНООР

Тийм Сүхбаатар



БАРААНЫ НАГСАЛТ - А

БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСААС
БҮГД НАЙРАМДАХ АРДЧИЛСАН ГҮРМЭН
УЛСАД 1971 ОНД НИАЛУУЛЭХ БАРАА

Д/Л	Барааны нэр		Үзэлэх нэгж Тоо бууруу үнэ
I.	Мах, махан бутээгдэхүүн	тонн	2500
2.	Хонини халуун угаалгын ноос	тонн	400
3.	Ахар, хурганы ноос	тонн	100
4.	Тэмээний ноос	тонн	150
5.	Низааны ноос	тонн	125
6.	Адууны хялгас /дэл, сүүл/	тонн	70
7.	Сарлагын хялгас	тонн	70
8.	Үхрийн сүүл	тонн	5
9.	Өлөн гэдэс	мян/тог.	200
10.	Савхийн эдлэл	мян/руб.	600
Үүнээс:			
	Савхийн дээл	мян/шир.	9
II.	Тарваганы арьс	мян/шир.	60
I2.	Яс-махны ба цусны гурил	тонн	800
I3.	Гянт болд	тонн	30
I4.	Техникийн гранат	тонн	60
I5.	Гилтганиур	тонн	50
I6.	Шуудангийн марк	мян/руб.	5
I7.	Бусад Бараа	мян/руб	50



БАРААНЫ ЗАГСАЛТ - Б

БҮРД НАЙРАНДАХ АРДЧИЛСАН ГЕРМАН УЛСААС
БҮРД НАЙРАНДАХ МОНГОЛ АРД УЛСАД 1971
ОНД НИМЛҮҮЛЭХ БАРАА

Л/Л	Барааны нэр	Хэмжих нэгж	Тоо бууруу дүн
I.	Хэвлэлийн машин ба хэрэгсэлүүд	мян.руб	120,0
2.	Мах комбинатын төхөөрөмж, салбаг ба материалууд	мян.руб	250,0
3.	Хөнгөн үйлдвэрийн машин ба салбаг хэрэгсэл	мян.руб	33,0
4.	Эмчилэг, зураг, лабораторийн хэрэгсэл ба салбаг	мян.руб	50,0
5.	Гүн хэвлэлийн цаас	тонн	200
6.	Телетайны цаас	мян.руб	1,3
7.	Тооны машинууд, түүний салбаг	мян.руб	60,0
8.	Холбооны төхөөрөмж түүний салбаг	мян.руб	20,0
9.	Цахилгаан бараа	мян.руб	18,0
Үүнээс: а/Хаймэлэктрик		мян.руб	8,0
б/Электротехник		мян.руб	10,0
10.	Хэвлэлийн будгууд	мян.руб	30,0
II.	Арьс шир боловсруулахад туслах материал /Анзолвен РК-I/	тонн	80
12.	Гурванхлортатилек	тонн	250
13.	Химийн төрөл бурийн бараа	мян.руб	0,5
14.	Хивсний үйлдвэрийн салбаг, материал	мян.руб	70,0
15.	Хедее аж ахуйн машини салбаг	мян.руб	0,2
16.	Суудлын вагонууд	ширхэг	5
17.	Вагоны салбаг	мян.руб	10,0
18.	Тослох материал	мян.руб	6,1
19.	Магнитфоны лент	мян.руб	5,4

20.Карл Цайсс үйлдвэрийн сүтээгдэхүүн	мян.руб	50,0
21.Хивс ба хивсэнцэр	мян.руб	75,0
22.Сулжмэл эдлэл	мян.руб	345,0
23.Хоний хивс	мян.шир	8
24.Ойнны зүйл	мян.руб	162,0
25.Цонхны тор ба чимэглэлийн даавуу	мян.руб	74,0
26.Небелийн даавуу	мян.руб	24,0
27.Шалгай	мян.руб	108,5
28.Хагас ноосон даавуу	мян.метр	200 ^x
29.Бичгийн машин ба сэлбэг	мян.руб	62,0
30.Цаг	мян.руб	8,0
31.Хулдаас	мян.метр ²	150,0
32.Үгээлгүн нунтаг	тонн	580
33.Гоо сайхны бараа	мян.руб	100,0
34.Цахилгаан товч	мян.руб	12,0
35.Хүүхдийн тоглоом	мян.руб	13,5
36.Хөгжмийн бараа	мян.руб	25,0
37.Гэрэл зургийн материал /цаас, хальс/	мян.руб	35,0
38.Гэрэл зургийн хор	мян.руб	6,0
39.Гэрэл зургийн аппарат түүний хэрэгсэл	мян.руб	37,0
40.Усчний сандал	мян.руб	10,0
41.Ливо	гк.литр	900
42.Кино, магнитны хальс Үүнээс: магнитны хальс	мян.руб	83,2
43.Эм ба хортныг устгах бодис	мян.руб	60,0
44.Техникийн зориулалттай гэрэл зургийн хальс	мян.руб	16,0
45.Зочид буудлын төхөөрөмж	мян.руб	470,0

x/ - Үүнээс 50 мянган метрийг 1972 оны I-р улиралд нийлүүлэнэ.



46.Бэлэн хувцас	мян.руб	209,0
47.Гутлын тос	мян.руб	13,0
48.Жижиг бараа	мян.руб	35,0
49.Гэр аж ахуйн цахилгаан бараа ба листрууд	мян.руб	96,7
50.Бичгийн цаас	тонн	50,0
51.Хүчинсны харэгсэл	мян.руб	20,0
52.Сойз, багс ба шүүр	мян.руб	5,0
53.Усчний ба баарни төхөөрөмж	мян.руб	53,0
54.Шаазангийн үйлдвэрийн машин ба төхөөрөмж	мян.руб	214,0
55.Дууриамал арьс ба номын хавтасны материал	мян.руб	20,0
56.Бусад бараа	мян.руб	30,0